



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ингэн эрдэнэ ОНӨААТҮГ -ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2023/10/НА-СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2023 оны 3 дугаар сарын 15

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Алтантуяа

Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	5
3.1 Байгууллагын үйл ажиллагаа	5
3.2 Компанийн гадаад дотоод орчин.....	5
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	6
4. Аудитын тайлан	7
4.1 Ерөнхий зүйл	7
4.2 Материаллаг байдал	7
4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	7
4.4.1 Шилэн дансны мэдээлэл.....	7
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
4.5.1 Завсрын аудитын талаар	8
4.5.2. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
5. Аудитын илрүүлэлт	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИНҮТ	Иргэний нисэхийн үндэсний төв
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.03.15 №

2/129

танай _____-ны № _____-т

Г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ингэн эрдэнэ ОНӨААТҮГ-ЫН 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Ингэн эрдэнэ ОНӨААТҮГ-ЫН 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

• 005020430

D:\alban bichig\A4-toot.docx

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Ингэн Эрдэнэ ОНӨААТҮГ-ын ингэний сүүний үйлдвэрлэлийн зориулалттай ажлыг байрыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж барилыг ажлын явц 95 хувийн хэрэгжилттэй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд 212,910.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг Ингэн Эрдэнэ ОНӨААТҮГ хүлээн авч тайланд онд үндсэн хөрөнгийг орлогоор бүртгээгүй ба аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.02.13-ны өдрийн 13/11 тогтоолоор Ингэн Эрдэнэ ОНӨААТҮГ -д бүртгэх шийдвэр гарсан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	0.0	63,700.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	0.0	63,700.00
1.3	Нийт хөрөнгийн дүн	0.0	63,700.00
2.1.1.1	Дансны өглөг	0.0	896,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг	0.0	8,618,087.00
2.1.1.3	Татварын өр	0.0	754,120.88
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0.0	2,253,540.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	0.0	12,521,747.88
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.0	
2.2	Өр төлбөрийн нийт дүн	0.0	12,521,747.88
2.3.9	Хуримтлагдсан ашиг	0.0	-12,458,047.88
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	0.0	63,700.00

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
8	Бусад орлого	0.0	1,001,000.0
12	Бусад зардал	0.0	13,459,047.9
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.0	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	0.0	-12,458,047.9
20	Татварын дараах ашиг (алдагдал)	0.0	-12,458,047.9
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	-12,458,047.9

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	0.0	0.0	0.0
2	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.0	-12,458,047.9	-12,458,047.9
3	2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	0.0	-12,458,047.9	-12,458,047.9



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1	Мөнгөн орлогын дүн	0.0	1,001,000.0
1.1.6	Бусад мөнгөн орлого	0.0	1,001,000.0
1.2	Мөнгөн зарлагын дүн	0.0	937,300.0
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	0.0	159,500.0
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.0	773,000.0
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.0	4,800.0
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	63,700.0
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	0.0	63,700.0
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	0.0	63,700.0

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Сүүний үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх, бус нутгийн мал сүргийг өндөр ашиг шимтэй малаар сайжруулж, сүү үйлдвэрлэлийн бүс нутгуудад бэлтгэсэн сүүг уламжлалт технологи ашиглан зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсруулж, олон нэр төрлийн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, сав баглаа боодолжуулах, дотоод гадаадын зах зээлд нэвтрүүлэх үйл ажиллагааг кластерийн зохион байгуулалтаар хөгжүүлж хуурай сүүний үйлдвэр байгуулах зорилгоор аймгийн ИТХ-ын 2021 ны 3/7 дугаар тогтоолоор “Ингэн эрдэнэ” ОНӨААТҮГ-ыг байгуулж дүрмийг баталсан байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022.10.06-ны өдрийн А/620 дугаар захирамжаар “Ингэн эрдэнэ” ОНӨААТҮГ-ын бүтэц, орон тооны дээд хязгаарыг 4 алба, 25 орон тоогоор баталсан бөгөөд тайлант онд үйлдвэр ашиглалтад ороогүй, 4 орон тоотой ажилласан байна.

Байгууллагын эрхэм зорилгыг “Ингэний ферм байгуулж сүүг хатааж боловсруулан нэмүү өртөг шингэсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан биологийн идэвхт хүнсний бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх” гэж тодорхойлсон ба 2022 онд үйлдвэрлэлийн үндсэн үйл ажиллагаа явагдаагүй бэлтгэл ажил хийгдэж байна.

3.2 Компанийн гадаад дотоод орчин

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг оновчтой төлөвлөхийн тулд аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголттой болсон.

Дотоод аудитын чиг үүргийг өнөөгийн байдлаар үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлээгүй тул аймгийн ИТХ-аас “Ингэн эрдэнэ” ОНӨААТҮГ-ын хяналтын зөвлөлийг батлаагүй байна.



Тайлант хугацаанд Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт орсон, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ба байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Ингэн эрдэнэ” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, санхүүгийн программ хангамж үйл ажиллагаандаа нэвтрүүлээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Ингэн эрдэнэ” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэгдсэн.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	0.0	63.7
Нийт хөрөнгийн дүн	0.0	63.7
Дансны өглөг	0.0	12,521.7
Хуримтлагдсан ашиг	0.0	-12,458.0
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	0.0	63.7

Эх сурвалж:2022 оны санхүүгийн тайлан

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.09.16-ний өдрийн 10/47 дугаар тогтоолоор Хонгорын хүдэр ХХК-ийн үйл ажиллагааны орлогоос 20,000.0 мянган төгрөгийг Ингэн эрдэнэ ОНӨААТҮГ-ийн үйл ажиллагаанд зарцуулан хуваарилах шийдвэр гарсан.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/537 захирамжаар Хонгорын хүдэр ХХК-иас орох шлам борлуулсны орлогыг аймгийн ОНХС-д төвлөрүүлэхээр гэрээ байгуулсан байхад Хонгорын Хүдэр ХХК-иас 1,000.0 мянган төгрөгийг Ингэн эрдэнэ ОНӨААТҮГ-ын харилцах дансанд шилжүүлсэн байна.

Тус газрын харилцах дансанд 1,000.0 мянган төгрөг орсноос 937.3 мянган төгрөгийг зарцуулж Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 63.7 мянган төгрөг байна. Төрийн банкин дахь харилцах дансны үлдэгдлийг дансны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулсан байна.

Өр төлбөр данс 13,175.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь 2022 оны 10 сард 1 ажилтан, 11-12 сард 5 ажилтны цалинг олгоогүй байгаа ч нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээ тайланд мэдээлж цалин, НДШ, ХХОАТ-ын өглөг үүссэн байна.

Тайланд онд 12,458.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Үйл ажиллагаа 2022 оны 11 сараас эхэлсэн тул тайланд оны зорилтот түвшнийг батлаагүй байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Ингэн эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг дарга Д.Хишигбаяр танд танилцуулж байна

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төрийн өмч, хөрөнгийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Ингэн эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дүгээр сарын 15-ны өдөр ирүүлсэн.

Тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг захирал Д.Хишигбаяр, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Л.Дуламсүрэн нар зурсан байна.

Компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 13,459.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 201.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 141.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.4. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.



Шилэн дансны сайтыг 2022 оны 12 сард нээсэн. Цалингийн зардлаас дээш 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээ байхгүй болно.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

4.5.2. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2022 онд үйл ажиллагаа эхэлсэн..

4.6. Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан Ингэн Эрдэнэ ОНӨААТҮГ-ын ингэний сүүний үйлдвэрлэлийн зориулалттай ажлыг байрыг ашиглалтад оруулах.

5. Аудитын илрүүлэлт

5.1 Санхүүгийн тайлангийн залруулга

Аудитаар нийт 12,521.7 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг санхүүгийн тайланд залруулж бүртгэв.

1. Компанийн албан хаагчдын цалинг олгоогүй ба 2022 оны 10 сард 1 ажилтан, 11-12 сард 5 ажилтны цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээ тайланд мэдээлж цалин, НДШ, ХХОАТ-ын өглөг үүссэнийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэж залруулсан.

Аудитаар нийт 3 зөр²чил илэрч зөрчил арилгах 3 зөвлөмж хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

1. Компанийн удирдлага зохион байгуулалттай холбоотой асуудал

1. Илрүүлэлт: Аймгийн ИТХ-аас Ингэн Эрдэнэ ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн батлаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Ингэн Эрдэнэ ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийг аймгийн ИТХ-д хүсэлт тавин шийдвэрлүүлэх.

2. Илрүүлэлт: Тайланд оны зорилтот түвшнийг батлаагүй байна

Өгсөн зөвлөмж: Тайлант оны зорилтот түвшин, үйл ажиллагааны орлого, зардлын хэмжээг төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан, үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланг Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж байх.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

3. Илрүүлэлт. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, санхүүгийн программ хангамж үйл ажиллагаандаа нэвтрүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, компанийн үйл ажиллагааны онцлогтой уялдсан нягтлан бодох бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөх. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, компанийн үйл ажиллагааны онцлогтой уялдсан санхүүгийн программ хангамж ашиглах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Компанийн албан хаагчдын цалинг олгоогүй ба 2022 оны 10 сард 1 ажилтан, 11-12 сард 5 ажилтны цалинг нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээ тайланд мэдээлж цалин, НДШ, ХХОАТ-ын өглөг үүссэнийг зардлаар бүртгээгүй	1	13,459.0					1	13,459.0				
Дүн	1	13,459.0					1	13,459.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Аймгийн ИТХ-аас Ингэн Эрдэнэ ОНӨААТҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн батлаагүй	1	0					1	0				
Тайланд оны зорилтот түвшнийг батлаагүй	1	0					1	0				
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, санхүүгийн программ хангамж үйл ажиллагаандаа нэвтрүүлээгүй байна	1	0					1	0				
Нийт	3	0					3	0				

---oOo---

